

“МОНГОЛ УЛСТАЙ ХИЛ ЗАЛГАА НУТАГ” НОМЫН ТУХАЙ ТОВЧ



ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D) Ч.Батцэцэг сүүлийн арваад жил ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улс, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны тухайд судалгаа хийж, бичсэн эрдэм шинжилгээ-судалгааны өгүүллүүдээ эмхэтгэн “Монгол Улстай хил залгаа бүс нутаг” (12хх) нэртэй орон судлалын номыг УБ, 2007 онд “Бемби сан” хэвлэх үйлдвэрт хэвлүүлжээ.

Уг ном 2 хэсгээс бүрдэнэ. Нэгдүгээр хэсэгт: “ОХУ-ын БНБУ-ын түүхэн хөгжил”; “Монгол Улс, ОХУ-ын субъект Бүгд Найрамдах Буриад Улсын харилцаа, хамтын ажиллагаа”; “Монгол Улсын хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагаа”. Хоёрдугаар хэсэгт: “БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны түүхэн хөгжил”; “БНХАУ-ын “Баруун бүс нутгийн хөгжлийг эрчимжүүлэх бодлого дахь ӨМӨЗО”; “Монгол Улс БНХАУ-ын харилцаанд ӨМӨЗО-ны эзлэх байр суурь”

зэрэг өгүүллүүд багтсан байна.

Өнөөдөр олон улсын эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаанд бүс нутгийн хамтын ажиллагаа зонхилох болжээ. Ялангуяа манай улстай хил залгаа бүс нутгийн ард түмний ахуй, амьдралын хэв маяг, ёс заншил, уламжлал, хэл соёл, эдийн боловсролын нийтлэг өвөрмөц байдлын давуу тал, нөхөн хөгжих, хамтын ажиллагааг илүү бодитой хөгжүүлэх боломж зэрэг бие биеэс хамааралтай зүйл ихээхэн чухал болж байна. Иймээс Монгол Улстай хил залгаа бүс нутгийн хамтын ажиллагаанд хоёр хөршийн монгол угсаатан, эсгий туургатан нүүдэлчин ард иргэдийн түүх, хэл бичиг, соёл уламжлал харилцан ойлголцоход чухал үүрэг гүйцэтгэх боллоо.

Монгол Улстай хил залгаа бүс нутгийн ард түмний дунд бодит ойлголт, харилцан итгэлцэл, найрсаг уур амьсгалыг бий болгох, уншигч олон түмний танин мэдэхүйн хүрээг тэлэхэд энэ номын ач холбогдол оршино.